



**ТӨРИЙН ӨМЧИЙН БОДЛОГО,  
ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН ХУРАЛДААНЫ  
ТЭМДЭГЛЭЛЭЭС**

2023 оны 05 сарын 30 өдөр

Дугаар 14

Улаанбаатар хот


Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2023 оны 05 дугаар сарын 30-ны өдрийн 15 дугаар хуралдааны тэмдэглэлд:

**ХҮ.15. ХЭЛЭЛЦСЭН нь:**

Соёлын яамны харьяа төрийн өмчит байгууллагуудын үндсэн хөрөнгөд бүртгэлтэй хөрөнгийг (түүх, соёлын дурсгалт зүйлс) Чингис хаан музейд балансаас балансад шилжүүлэх тухай.

**ШИЙДВЭРЛЭСЭН нь:**

Засгийн газрын 2019 оны 7 дугаар сарын 3-ны өдрийн “Чингис хаан музей байгуулах тухай” 280 дугаар тогтоолын 2.2 дахь заалтаар музейн сан хөмрөгт Чингис хааны болон Монголын эзэнт гүрний түүхэнд холбогдох үзмэр, эд өлгийн зүйлийг шилжүүлэн авах, шинээр бүтээх, гадаад улсын музейд хадгалагдаж байгаа түүхэн дурсгалуудыг хуулбарлан авах боломжуудыг судлан, зохих арга хэмжээ авахыг Соёлын сайдад даалгасны дагуу төрийн өмчит музей болон холбогдох байгууллагаас үзмэр, эд өлгийн зүйлийг шилжүүлэн авах асуудлыг дэмжээд, эзэмшигч байгууллагатай зөвшилцөн (саналыг авч) нэг бүрийн үнэ өртөг, тоо хэмжээ бүхий жагсаалтыг бэлтгэн ирүүлсний үндсэн дээр шийдвэрлүүлэх нь зүйтэй” гэж үзэв.



ТӨРИЙН ӨМЧИЙН БОДЛОГО, ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗАР